

Өвөр монголын нэрт яруу найрагч Артайн
эх орны сэдэвт бүтээлийн онцлог

Бүрэнтөгсийн ТОГТОМЖ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх ухааны сургууль

Received: 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Эх орны тухай магтан шүлэглэсэн бүтээл хэн бүхний зүрх сэтгэлд гүн хоногшидог. Учир нь хүн бүрд эгнэгт хайрлаж явах сэтгэлийн хэмжүүр гэж бий. Артайн эх орны шүлгүүдэд нутгаа санасан сэтгэл багагүй илэрдэг. Мөн нутгийнхаа ширхэг шороо, чулуу бүхнийг хайрлаж, бахархаж, биширч, нандигнаж бичсэнээрээ ялгарч байна. Ялангуяа тэнтэр тунтар алхахаас эхлэн тэмүүлэх хүлгийн зоон дээр гарсан, улмаар тэнхээ муудаад өтлөхийн цагт түшээд авна хэмээн цаг хугацааны нарийн уялдаа холбоог шүлэглэсэн нь бий. Түүний бичсэн эх орны сэдэвт шүлгүүд хэл найруулга, үгийн сангийн хувьд эгэл энгийн ч ямар нэгэн зүйлийг товойлгон цэцлэхдээ түүнийхээ мөн чанарыг алдагдуулалгүй илэрхийлдгээрээ гарамгай нь дүрслэлийн уран чадвартай нь холбогдоно. Уран чамин, нарийн нандин дүрслэлээ эх орны сэдэвт шүлэгтээ илүүтэй шигтгэдэг нь Артайн туурвил зүйн мөн чанарыг тодорхойлохын зэрэгцээ уншигчдын зүрх сэтгэл, хайр хүндэтгэлийг хүлээхэд онцгой байртай байна.

Түлхүүр үгс: Артай, эх орон, яруу найраг, утга уянга, онцлог

**Motherland Lyrics in the Literature of Artai,
the Famous Poet of Inner Mongolia**

TOGTOMJ Burentugs

School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In Artai's poem on the theme of the motherland, there is a lot of nostalgia for the country. There are many poems where he also wrote with treasure about the earth and stones of his beloved, proud and admired homeland. He has surprisingly well described the precise connection of time in poetry on motherland role narrating that motherland supports you from when you start to walk until you aspire to horses and one leans on it when he feels weak. It can be said that his poems on the theme of the motherland are simple in terms of imagery and composition vocabulary and when

* © Тогтомж, 2025, Email: 1300579540@qq.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

he embosses something he is excellent at expressing its essence without losing it. It is obvious that he has embedded his detailed description in his poems on the theme of the motherland and that he has touched the hearts of others and received the love and respect of his people with his ordinary language. Even though these poems on the theme of the motherland of Artai's poems have a lot of simple language the meaning behind them is deeply reflected with the narrative closely connected to the cause and reason the great worship of non-lyrical understanding and the love and pride for the motherland. For this reason, it can conclude that in addition to these poems, many of his poems in praise of the motherland are popular among the Mongolian people in China.

Key words: Artai, Motherland, Poem, Lyrics, Characteristic

1. Удиртгал

Эрдэмтэн Сүюүгэ “Шүлэг амьдралаас эрэлтэй, амьдралыг тусгадаг. Гэвч шууд тусгадаг бус. Амьдралыг сэтгэл зүрхтэй холбож уянга дуу шиг илрүүлж гаргадаг. Шүлгийн агуулгын мөн чанар нь сэтгэлийг уянгалахад оршдог. Хүүрнэл нь сэтгэлийн давалгаанд түлхэгдэж сэтгэл бодлын үсрэлтийг авчирдаг. Иймээс сэтгэл бол шүлгийн гол агуулга болно” (Сүеэгэ, 2000:63) гэжээ. Цаг үеийн хөгжил хувирлыг даган шүлэгчийн дотоод сэтгэл бас улиран хувьсдаг. Тухайлбал, “Огторгуй хөхрөн хөхөрч ой зүйвэр цэлгэлэм өвсний хийд налархуйяа үхэр хоньд харагдмуй” (Сүеэгэ, 1998:462) бэлчээр нутаг XX зууны сүүлчээр хомстож нийгмийн тулгамдсан асуудлын нэг болов. Энэ талаар зохиолчид ч анхаарал хандуулж Артай “Бэр цэцэг”, “Ээж нуур”, Чи.Мэргэн “Мод огтлох дуун”, Ё.Эрдэнэтогтох “Залуу бүргэдийн хилэн” зэрэг олон шүлэг бичсэн тул энэ мэт нүүдлийн сэтгэлгээг “Сэтгэл нүүдэл” гэж нэрлэж байна. Энэ үеэс эхлэн монгол яруу найргийн өргөн сэтгэлгээ, баялаг хэл, яруу хөг аясын уламжлалд суурилж, мөр бадаг бүхэндээ эх орон, төр түмэн, нутаг орноо зураглан дүрсэлж, магтан дуулахдаа уянгын баатрын болон уншигчдын хэмжээлшгүй хайр энэрлийг тусгасан нь Артайн яруу найргийн туурвилд онцгой жин дарж буй болно.

2. Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших аргуудыг яруу найрагч Артайн эх орны сэдэвт яруу найргийн бүтээлүүдэд тулгуурлан гүйцэтгэв.

3. Эх орны сэдэвт шүлгийн онцлог

Уран бүтээлийн эхэн үедээ зохиолч дан ганц нам төрийг талархан бичих бус хөдөө нутаг, хөдөлмөрчин олноо магтан дуулж байсан юм. Артайн “Миний монгол эх орон”, “Нутгийн шороо”, “Шүлэг минь! Бос”, “Зулзган ногоо”, “Үдэш”, “Хөх давсны талс” зэрэг шүлгүүдэд нь иймэрхүү зураглал ажиглагддаг. Артайн эх орон, төр түмэн, нутаг орны магтаал уянга-амьдралын үнэнтэй нийцэн чигч сэтгэлийг гаргахдаа амьд дүрслэг сэтгэхүйгээр жигүүрлэн “Дөрвөн хүний бүлэг”-ийн өнгөрсөн үеийн худал хуурмаг уриа тунхаг мэт магтаал дууллаас огт өөр нөлөө тусгалтай байж, сүрлэг идрүүн хөг аясаараа ялгарч байна.

Тухайн үеийн найрагчид цаг үеийн нөлөөнд автаж улс төрийн “багаж” болж байсан бол Артайн шүлгийн анхны мөртүүдээс эзэн хүний омог төгөлдөр зан бүрэн тодорч байжээ. Сүүлийн үед энэхүү үүрэг, хариуцлага нь тэлж ард олон, хойч үедээ эх нутаг, газар шороо, алив бүхэндээ эзэн болж явахыг уриалсан нь нэмэгдсэн байна. Түүний шүлэгт “Миний” хэмээн нэгдүгээр биед хамаатуулан нэрлэсэн мөр бадаг цөөнгүй бий. Тухайлбал “Миний үг”, “Миний монгол орон”, “Миний Өвөр монгол”, “Миний нутаг”, “Миний багш”, “Миний жаахан нуур”, “Миний ерөөл”, “Миний жаргал”, “Миний нутгийн нэр” гэх мэт. Энэхүү I биеийн төлөөний үг нь өөриймсүүлсэн санаа төдийгүй эх орон, газар шорооныхоо ямагт эзэн байх иргэний үүрэг, ухамсар, хариуцлагыг сануулснаараа гүн санаатай болно.

“Газар нь миний! Гаралт нь ч миний!”

“Эх орон гэдэг үг бол
Эрх жаргал гэсэн үг, эзэн нь би гэсэн үг
Эх орноо алтал гэдэг үг бол
Энэхэн чигээрээ эрлэгт хүрлээ гэсэн үг!” гэсэн мөр бадгууд нь хэдийгээр Маяковскийн
“Гудамж нь ч миний,
Байшин нь ч миний юм!” ,
“Үндэс чинь юу юм? (Коментерн гэнэ ээ? Эхнэр хүүхэн, орон байр, мөнгө зардал энэ
бүхнээ)

-Эх орон, аз жаргал юм шүү дээ.
Агуу энэ “газрынхаа төлөө”
Амьдрал хөдөлмөр баяр ёслол, хар үхэлд ч
Ахин ахин явж чадна, би!” зэрэг шүлгийн санааг ямар нэг байдлаар үргэлжлүүлсэн мэт
боловч

“Тавагтай махандаа
Таван тохой биедээ л
Эзэн болж төрөөгүй би
Тал нутагтаа, дархан эх улсдаа
Эзэн болж төрсөн юм, би” хэмээн тунхагласан содон бадгууд нь уншигчдын сэтгэлд
хоногшсон байдаг. “Эзэн учир омголон, эзэн учир эрхтэй” гэдэг шиг газар шороо, эх орныхоо
уул ус, тал хөдөө, гол горхи, цэцэг навч, өвс намгаа хүртэл өөриймсүүлж “хайртай нутгийн
чинь хайлсны намаа хугарахад, хуруу чинь хугарсан шиг өвдөх ёстой” хэмээн хүйн холбоог
уянгын хэлээр урласан юм. Дээрх дөрвөн бадгаас үзэхэд Артай хувь хүн төдийгүй бие хүн
байхын утга учрыг дэвшүүлж харь үндэстний содон зүйлсийг шүлэгтээ уусган монголчуудын
гоо зүйн таашаалын уламжлалыг өөрийнхөө урлагийн хэв намбад идээшүүлэн дуураймал
шүлэг бус, бүтээмэл найраг урласан байна.

Артай нь улс үндэстэн, ард түмнээ эх орныхоо нэгэн амь болгон шүлэглэдэг яруу найрагч
юм. Түүний найргийн санд эх орны сэдэвтэй олон шүлэг бий ч “Миний монгол орон” (1979),
“Газар шороо” (1992), “Сайхан шинэлэв үү, эх орон минь” (1995), “Монгол гэр”, “Эх орон”
(1989), “Нутгийн шороо” “Хөндөшгүй дархан тал минь” “Төрсөн нутаг” зэрэг эх нутаг, газар
шороогоо магтан дуулсан шүлэг зохиол ялгардаг. Ялангуяа “Миний Монгол орон” (1979)
шүлэгтээ

“Онгон хээр талын чинь
Хүү нь болж төрөөд
Одноос олон сүргийн чинь
Эзэн нь болж заяагдаад
Цадсан тугалын хүзүүвчнээс
Чирэгдэн байж өсөхөд
Цантсан хүлгийн жолооноос
Чангаан байж өндийхөд
Боровтор хөрслөг царайг
Та над соёрхож билээ” (Артай, 2007:17) хэмээн ээж аав, элгэн саднаа уул толгод,
байгалийн үзэгдэлтэй адилтгасан нь нутаг хүүгийн шүтэлцээ гэж болно. Нүүдэлч амьдралын
суурь, энгийн амьдралыг хүүхэд наснаас нь таниулах түүний шүлгүүд хөдөө нутгийн
найрагчийн сэтгэмж нь гүн, сэтгэл нь тал шигээ уудам байдгийг бататгаж байна. Харахад
энгийн хэл, хэллэг боловч

“Цадсан тугалын хүзүүвчнээс
Чирэгдэн байж өсөхөд
Цантсан хүлгийн жолооноос
Чангаан байж өндийхөд
Боровтор хөрслөг царайг
Та над соёрхож билээ” гэсэн дүрслэл нь эгэл жирийн хөдөөгийн амьдралыг үзүүлэхдээ
хүний дайтай явахын төлөө эгэл жирийнээс энгүй уудам болсон тухай шүлэглэн бичсэнд яруу
найрагчийн урлах эрдэм тодордог.

4. Эх орны уянгын өвөрмөц эрэлхийлэл ба урлал

“Борогжуун хөдөөлөг зөнг (Та надад сургаж билээ)

Булбарай байсан биеийг минь (Дорвийг та хуримтлуулж билээ)” хэмээн шүлгийн мөр бадаг бүрд эх орноосоо өвлөсөн, өнө хойчийн ирээдүйн замыг заасан болохыг тодруулсан тайлбар дагалдуулсан нь түүний шүлгийн өвөрмөц сэтгэлгээ юм. Түүнчлэн “Эх орон” (1989) шүлэгт эх орон гэдэг ямархан гайхам, шим ертөнцийн гоо сайхныг хайрлах, энэрэн дотносоход ижий, бас хүүгийн зүрхний нэгэн хэмнэл болдог гэсэн санааг хөндсөн нь яруу найрагчийн эмзэг уян сэтгэл, эх орноороо бахархах өнгө аясыг гүнзгийрүүлжээ. Чингэхдээ эх орон минь би чиний төлөө хорин дөрвөн жил шүлэг бичлээ гэсэн нь яруу найрагчийн эх оронч сэтгэлийг илтгэх бас нэгэн хэмжүүр мөн.

“Цонхон дээр тавьсан нар

Цомтой шаргал цайнаас миний эх орон эхэлнэ

Чулуу хурууд хоёр адилхан амттай санагдана” гэсэнд өглөөний наран ургаж амьд бодис бүхэн сэргэж эхлэхэд эх орон түүнийг амилуулан, амьдралын сайн муу, жаргал, зовлонг тэнцүүлэгч их багш хэмээн тодорхойлжээ. Мөн байгаль хүн хоёрын хүйн холбоог нийтгэж

“Үүрээр эх орноо үүрээд хүү минь сургуульдаа гүйнэ

Үдэш эх орноо бүүвэйлсээр миний ээж зүүдэндээ инээнэ

Өнө үүрд эх орноо тэвэрсээр яруу найрагч саран доор зогсоно” (Артай, 2007:32) гэсэн нь хүн байгаль хоёрын хүйн холбоо, шүтэлцээгээр төлөөлүүлсэн уран сэтгэмж юм. Улмаар

“Хугархай мөчрийн боолт

Хурууны боолт зэрэг эмзэгтэй

Хунгийн цагаан далавч

Хүний цагаан санаа жигд дэрвээтэй

Хадтай шилийн морин ятга

Миний төлөө тачигнана

Хангайн сайхан монгол яргуй

Миний төлөө уйлна” хэмээн яруу найрагч, эх орон хоёрын харилцаа хамаарлыг буюу эх орон нь найрагчийнхаа төлөө сэтгэлээ дэвсдэг гэсэн санааг илэрхийлсэн нь бий. Шүлгийнхээ төгсгөлд

“Өндөр тэнгэрт уулан алга чинь дамнадаг болохоор

Өрөөсөн далавчтай ч уужим амьсгаанд чинь би нисдэг ээ

Өнчин зовлонд удаан жил шаналсан болохоор

Өрөөлөөс илүү би чамд хайртай байдаг аа” хэмээжээ.

Яруу найрагчийн эх орноо хайрлах, энэрэх, цаашлаад өрөвдөх сэтгэлийн өнгө аяс эл хэсэгт илэрч “Өрөөсөн далавчтай ч уужим амьсгаанд чинь би нисдэг” гэсэн ганц шадад алдаж эндэн өвдөг тохойгоо шалбалсан ч өргөөд босгох хүч ганцхан эх оронд минь үлддэг гэсэн утга уянгын зохицолдоог уялдуулжээ. “Сайхан шинэлэв үү, Эх орон минь” шүлэгт угсаатан үндэстний хамгийн том соёлын бас нэгэн хэлбэр болох хэлийг нэгтгэн шүлэглэсэн байдаг. Чингэж шүлэглэхдээ хүний орчлонгийн хамгийн гол хүчин зүйлээр төлөөлүүлэн шүлгийг илүү тод, товойм үзүүлсэн нь анхаарал татаж байна.

“Уурга тохойлдсон амьд бурхад минь

Уудам энэ дэлхийгээ өмсөж яваа малчид минь

Угсаа үндэстний нурууны яс

Ухаан бодлын соён гэгээрүүлэгч

Уушги зүрхний амин хүчилтөрөгч монгол хэл минь сайн шинэлэв үү!

Сайн, сайхан шинэлэв үү!” (Артай, 2007:21) гэжээ. Хэл нь тухайн улс үндэстний оюун соёлын дархлаа бөгөөд хүмүүсийн хоорондын харилцааны нэн чухал хэрэглүүрийн үүргийг аман яриа ба бичгийн хэлбэрээр гүйцэтгэдэг. “Хүн аман яриагаар санаа бодлоо солилцон үйлдвэрлэлийн ба нийгмийн харилцаанд оролцоно”. Мөн “хэл нь мэдээ мэдээллийн үүрэгтэй төдийгүй хүний сэтгэлд нөлөөлөх үүргийг ч давхар гүйцэтгэдэг чухал эрхтэн” (Гаадамба, 1989:99) билээ. Энэхүү хэлний гайхамшигт чанар яруу найргаар илрэн гардгийг Артайн шүлгүүд бататган үргэлжлүүлсэн юм. Түүний шүлгийн хэл хэллэг эгэл энгүүн атлаа ухааруулсан өнгө аястайгаараа өвөрмөц урлалтай гэж болно. “Сайхан шинэлэв үү, Эх орон минь” шүлгийн

*“Угсаа үндэстний нурууны яс
Ухаан бодлын соён гэгээрүүлэгч
Уушги зүрхний амин хүчилтөрөгч*

Монгол хэл минь сайн шинэлэв үү!” гэсэн бадаг нь эх хэл бол монгол хүний соёлын тулгуур багана гэдгийг илэрхийлж яруу хандсанаараа содонсож байна. Монгол хүн монгол хэлээрээ ярьж бичих нь түүхийн үнэт зүйлийнхээ нэг хэсгийг хадгалан хамгаалж байгаагийн нэг хэлбэр билээ. Энэхүү шүлэг бичлэгийн өвөрмөц хэлбэрүүдийг ашигласан байна.

1.Эзэн хүний нутгаа санасан сэтгэл нь бадаг тус бүрийн “Сайн шинэлэв үү!

Сайхан, сайн шинэлэв үү” гэсэн давталтаар эх орныхоо амрыг эрж байгаа боловч нөгөө талаар энэ нутгийн эзэн нь уянгын “би” баатар болохоор эрх жаргалынхаа өлгий болсон эх нутагтайгаа мэндлэх нь зүй ёсны хэрэг гэсэн утгыг илтгэж буй нь цөөн тоот үндэстний сэтгэлийн түрлэг болж байна. Ердийн үед аав ээж, найз нөхөдтэйгөө л “Сайн байна уу? Сайхан шинэлэв үү?” гэж ахмадаа хүндлэн амар мэндийг нь эрэн мэндлэхээс эх оронтойгоо ийнхүү мэндэлнэ гэдэг оюун санааны эзэд нь зохиолч, уран бүтээлчид байдаг гэсэн сэтгэмж юм.

2.Шад бүрийн төгсгөлийг “минь” нөхцөлөөр ихэвчлэн ижилсүүлсэн нь миний гэсэн хамаатуулах утгыг илэрхийлж эх орны юм бүхэн өөртэй нь амь нэгтэй гэсэн санаанд холбогдож байна. “Туршлага сургамж минь”, “Монгол цэцэгс минь”, “Морьтой цолмон минь”, “Ирээдүй минь”, “Амьд бурхад минь”, “Та бүхэн минь”, “Малчид минь”, “Өндөр шаргын минь”, “Уншигчид минь”, “Элэг зүрхэн дотор минь”, “Ширээний минь” гэх мэт монгол хүний нандин чанар, эх нутгаа бүхэлд нь “минь” гэсэн төлөөний үгээр холбон дүрсэлжээ.

Эх орон, ёс заншлын сэдэвт Артайн энэ мэт шүлгүүд энгийн хэллэгтэй боловч утга санаагаа гүн сэтгэмжилсэн, учир шалтгааны нарийн уялдаа холбоо бүхий өгүүлэмж, утга уянгын бус ухаарч ойлгохын шүтэн барилдлагаар эх орноо хайрласан, түүгээрээ бахархсан өнгө төрхийг агуулжээ. Ийм учраас түүний эх орон, нутаг усаа дээдэлсэн шүлгүүд нь Дундад улсын Монгол үндэстний дунд алдар хүндийг олсон юм. Эх орныхоо төлөө тасралтгүй олон жил шүлэг бичсэнээ зарласан нь хоосон уянгалан магтах бус энгийн хүүрнэл атлаа бодтой хандал болон харагдаж байна. Ингэхдээ итгэл үнэмшил, энэрэл хайраа зориулж ирснийг “хоосон атлаа цатгалан туулсан” өдрүүдээр нээж мөнөөх л эгэл энгийн өглөөнөөс эх орон эхэлдэг нүүдэлч ахуйг зураглажээ. Чулуу, хурууд хоёр адилхан амттай санагдах нь эх нутгийнхаа хөрс шороо бүхнийг хайрладаг яруу найрагчаас л гарах зүйрлэлт сэтгэмж болно. Улмаар эх орноо үүрч, тэвэрч, бүүвэйлэх утгын сэтгэмж нь өнгөрсөн, одоо ба ирээдүйг төлөөлсөн дүрслэлт өгүүлэмж, уянгын яруу жигүүрлэлт юм.

Тиймээс

“Өглөө болгон

намайг дууддаг

эх орон минь

Өнөөдөр хоёулаа

дөчийн давааг

ардаа хаялаа

Өндөр тэнгэрт

уулан алга чинь

дамнадаг болохоор

Өрөөсөн далавчтай ч

уужим амьсгаанд чинь

би нисдэг ээ” (1989)

хэмээн эх оронтойгоо өглөө бүр нарны сацрагаар холбогддог гэсэн санаагаа өвөрмөц дүрслэлээр уран тойруулж найрагчийн нас, уул бол нарны алга гэсэн төлөөлүүлэл, сэтгэл гундуу ч эх орноо хараад их хүч ордгийг яруу уянгын туйлд хүргэжээ.

Артай найрагч Д.Нацагдоржийн “Миний нутаг”-ийг хацар дүүрэн нулимстай уншиж байснаа дурсаж “хайр сэтгэл ямар хүчтэй вэ” гэж бичсэн нь бий. Энэ утгаар нь сэтгэлийн

долгисол ихтэй найрагчийн эх орон, нутаг ус, ард түмнээ гэсэн хайр энэрлийн дүрэлзлийг шүлгийнх нь нэгэн жигүүр гэж болохоор байна.

*“Гарчгаасаа би айгаагүй
Гардаж бичихээсээ зовоогүй
Миний орон нартай
Монгол гэдэг нэртэй
Морин хуур чаддаг бол
Хөглөж байгаад дуулна би!
Молор эрдэнэ олддог бол*

Сийлж байгаад магтана би! (Миний монгол орон) гэх мэтээр Артайн шүлэгт хайр энэрлээ тогтоож дийлшгүй, асан дүрэлзсэн тэмүүллийг харуулсан ийм жишээ цөөнгүй юм. Зарим шүлгээ тархиараа бус зүрхээрээ бичсэн мэт сэтгэгдэл төрүүлдэг нь найрагчийн онгодын цалгиа, дотоод эрчим хүчээр тайлбарлагдана. Тиймээс “Дэлхийдээ би хайртай дээр нь монгол хэл байдаг” гэж бичсэн юм. “Эзэн” шүлэгт “эх орон”-ыхоо эзэн гэдгээ сүр жавхлантайгаар тунхагласан нь хайр энэрлийн тэсрэлтийн хүчийг илтгэж буй бол “Түүх” шүлэгт эх орон, түүх соёлдоо хайргүй хүнийг хатуу шүүмжилсэн нь үндэс удам, ардын гүн ухаандаа хайртайн учир юм. “Миний жаахан нуур -сэтгэлд яасан их юм бэ” гэдэг нь эргээ давсан усны халгиа шиг, номхоршгүй дүрэлзсэн хөх гал мэт тийм их сэтгэлийн ертөнц, оргилсон их давлагаан нүргэлүүлж байна.

5. Дүгнэлт

Артайн уран бүтээлийг сэдвийн хувьд

1. Эх нутгийн сэдэвт шүлэг

2. Улирлын сэдэвт шүлэг

3. Хайрын сэдэвт шүлэг гэсэн гурван үндсэн хэсэгт хуваан авч үзэж болохоор байдаг тул энд бид эхнийхийг авч үзлээ. Эдгээр сэдвийн хүрээнд яруу найргийн онцлогийг нь тодруулан дэлгэрэнгүй судалгаа хийсэн нь үгүй тул Артайн яруу найргийг судлан шинжлэх үүднээс зохиолчийн амьдралын хэв маяг, өр зөөлөн сэтгэл, хүн чанарын эрхэм нандин улбаа хэрхэн илэрч буйг туурвил зүйн үүднээс тодруулан авч үзэх нь цаг үеэ олсон шийдвэрлэлт юм.

1. Артайн шүлгийн эх орны сэдэвт эдгээр шүлгүүдэд энгийн хэллэг их боловч цаад утга санаагаа гүн тусгасан, учир шалтгааны нарийн уялдаа холбоо бүхий өгүүлэмж, утга уянгын бус ухаарч ойлгохын их шүтэн барилдлагаар эх орноо хайрласан, түүгээрээ бахархсан өнгө төрхтэй болжээ. Ийм учраас түүний эдгээр шүлгээс гадна эх орон нутаг усаа магтсан олон шүлэг нь Дундад улсын Монгол үндэстний дунд алдаршсан байна.

2. Артайн яруу найргийн туурвил зүй нь үгийн утга, уран дүрслэл, хэл найруулгын эрэлхийлэл, хурц дүрслэлийг ил далд хэлбэрээр тусгахдаа зөвхөн нэг зүйлд баригдалгүй чөлөөтэй сэтгэж, санасан бодсоноо яруу уянгалуулан бичдэгт оршино. Түүний шүлэглэх айдас хэмнэл, мөр бадаг хоорондын уялдаа зэргээс үзэхэд чөлөөтэй сэтгэж, үгийн сэлгэлт нь гоё чамин үгэнд баригдалгүй энгийн хэллэгийг гайхалтайгаар шигтгэдэг онцлогтой нь эл сэдэвт шүлгүүдээр баталгаажиж байна.

3. Эдгээр нь уянгалаг хийсгэлэн үгээр бус тухайн өгүүлж байгаа хүн, газар нутгаа нүдэнд харагдтал дүрслэн зурж чадсанд түүний бүтээлийн үнэ цэн, яруу гайхамшиг нь оршино. Учир нь нэгэн шүлэгтээ “Арьсаар биш алтаар бүрж зэвэрсэн худал үгсээ угаа, яруу найрагчдаа” гэсэн нь чамин үгэнд хэт автан шүлгийн харьцаа, утга агуулга алдагдаж буйд эмзэглэсэн сэтгэлийн үг, энгийн байдлыг эрхэмлэдэг уг чанарыг нь илтгэж байна.

4. Уран бүтээлийн эхэн үедээ эх орон, ард түмэн, төр засгаа магтан дуулж байсан бол байгалийн сайхныг зураглаж нийгмийн хөгжил хувирал, монгол нутгийн нүүдэл зэрэг олон сэдвээр баяжжээ. Тиймээс өнгөрсөн түүх ба ирээдүйн оюун сэтгэлийн ертөнц, үндэстний зориг санааны шинэ хүчийг уриалан дуудаж давшингүй боловсон, саруул сайхан ирээдүйг хүсэн зөгнөхдөө муу муухайг ташуурдан, үнэн сайныг уянгалан дуулсан нь эх орны сэдэвт шүлгүүдийг ч тойроогүй төдийгүй дөрвөн улирлын сэдэвт шүлгээр өргөжин баяжсан байна.

Ном зүй

- Артай**, (1998). Артайн шинэ шүлгийн сонгомол, Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Artai, *Artain shine shulgiin songomol* [A new elective works of Artai] Hoh hot: The National Institute of Inner Mongolian Publishing 1998]
- Артай**, (1985). Артайн шүлгийн сонгомол, Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Artai, *Artain shülgiin songomol* [An elective works of Artai] Hoh hot: The National Institute of Inner Mongolian Publishing 1985]
- Артай**, (1990). Бодлын цэнхэр яргуй, Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Artai, *Bodlyn tsenher hargui* [The blue path of mind] Hoh hot: The National Institute of Inner Mongolian Publishing 1990]
- Артай**, (1986). Давлагаа, Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо. [Artai, *Davlagaa* [The waves] Beijing: The National Institute of Publishing 1985]
- Артай**, (2004). Шүлгийн зоог, Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо. [Artai, *Shulgiin zoog* [The banquet of poem] Beijing: The National Institute of Publishing 1985]
- Артай**, (2007). Артайн шүлгийн түүвэр. Улаанбаатар. [Artai, *Artain shülgiin tüüver* [Artai's collected works] Ulaanbaatar: Bemby san LLC 2007]
- Гаадамба, Ш.** (1989). Утга зохиолын онолын үндэс. Улаанбаатар. [Gaadamba, Sh *Utga zokhiolyn onolyn ündes* [The principle of literature theory] Ulaanbaatar: The National Institute of Publishing 1989]
- Пүрэвдорж Д.** (2009). Нар тойрсон зам I боть. Улаанбаатар. [Purevdorj, D *Nar toirson zam* [The way around a sun] Ulaanbaatar: 2009]
- Сүеэгэ**, (2000). Монгол шүлгийн ухаан, Хөх хот, Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн хороо. [Suyuge, *Mongol shülgiin ukhaan* [The intellect of Mongolian poem] Hoh hot: The Publishing Institute of Inner Mongolian University 2000]
- Сүеэгэ**, (1998). Утга уянгын толт, Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Suyuge, *Utga uyangyn tolt* [The gameness of Lyrics] Hoh hot: The National Institute of Inner Mongolian Publishing 1998]